

ҮНДЭСНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ГҮЙЦЭТГЭХ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 04 сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

Хуралд 4 гишүүн оролцсон (ирц 80%), Хурал ҮЗЗ-ийн оффис, Далай тауэр, 701 тоотод 12:30-14:00 цагт болов.

1. Б.Мягмар, ҮЗЗ-ийн дарга,
2. Ж.Одгарьд, Шашны байгууллагын төлөөлөл
3. П.Анузаяа, ДЭМБ-ын мэргэжилтэн
4. Ц.Пүрэвжав, Олон нийтийн төлөөлөл

Урилгаар оролцсон хүмүүс:

1. Индермохан Нарула, СОНА-ны Багын Ахлагч
2. Н.Цогзолмаа, ХЗН-ийн Зохицуулагч
3. Ж.Лхамсүрэн, ХЗН-ийн Мэргэжилтэн
4. А.Баярзаяа, ЭМЯ-ЭҮТГ-ын мэргэжилтэн

ҮЗЗ-ийн гишүүд Гүйцэтгэх Хорооны хурлын хөтөлбөрийг санал нэгтгэйгээр хэлэлцэн баталж, Гүйцэтгэх Хорооны хурлыг ҮЗЗ-ийн дарга Б.Мягмар даргалав.

Хөтөлбөр 1. Глобаль сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр COVID-19 цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний талаар танилцуулж, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцэн батлах;

Б. Оюундарь: Глобаль сангаас улс орнуудад COVID-19 цар тахалтай холбоотой дэмжлэг үзүүлж байгаа ба үүнтэй холбоотой 3 дугаар сарын 24-ний өдөр ДЭМБ-ын суурин төлөөлөгчийн санаачлагаар ҮЗЗ, ХЗН, олон улсын байгууллагуудын төлөөлөл хамтарч уулзсан. Уг уулзалтаар одоогоор хэрэгжиж байгаа төслүүдээс хэмнэгдэх боломжтой санхүүжилтыг ХЗН-ээс ирүүлсэн ба дүн нь 171,560 ам.доллар болсон бөгөөд энэ нь ханшийн зөрүүнээс хэмнэгдсэн төсөв юм. Энэ талаар ҮЗЗ-өөс 2020 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр Үндсэн хүлээн авагч байгууллага болох ЭМЯ-нд мэдэгдсэний дагуу ЭМЯ-наас 4 дүгээр сарын 13-ны өдөр Эрүүл Мэндийн Сайдаас Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн үйл ажиллагаа, ханшийн зөрүүнээс хэмнэгдсэн 171,560 ам.доллар буюу нийт төслийн санхүүжилтийн 4.6 хувьтай тэнцэх санхүүжилтээр 11 ширхэг амьсгалын аппарат (нэг бүрийн үнэ 38.5 сая төгрөг) нийт 423,500,000 төгрөг мөн халдваргүйжүүлэх бодис нийт 53,640,000 төгрөг бүхий тоног төхөөрөмж, халдваргүйжүүлэх бодис авах хүсэлтээ ирүүлсэн.

2020 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн газрын даргаас халдваргүйжүүлэх бодисынхоо оронд амны хаалт аваад, 11 ширхэг амьсгалын аппаратаа хэвээр хадгалах саналыг илгээсэн. Үүнтэй холбоотой 2020 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр ҮЗЗ-ын нийт гишүүдэд цахим байдлаар танилцуулж ажлын 3 хоногт саналыг авсан. Нийт ҮЗЗ-ийн 21 гишүүний 20 гишүүнээс дэмжсэн санал ирсэн, уг 20 гишүүний нэг нь хөдөө орон нутагт явж байгаа тул имэйл явуулах боломжгүй байгаа ч дэмжинэ гэдгээ илэрхийлсэн. Харин 1 гишүүн нь татгалзсан санал ирүүлсэн. Глобаль Сангаас ирүүлсэн Guidance Note дээр ҮЗЗ-ийн гишүүн болгон саналыг дэмжсэнээр Глобаль Сан руу хүсэлт илгээх ёстой гэж заасан байсан. Хэрвээ

нэг гишүүн татгалзаж байгаа тохиолдолд яах вэ гэсэн асуудлыг би Монгол улсыг хариуцаж байгаа Аллан менежерээс асууж тодруулсан, үүнтэй холбоотой дэмжихгүй байгаа гишүүн нь тусдаа Глобаль Сан руу өөрийн тайлбарыг бичиж явуулах ба тэрэн дээр үндэслэн Глобаль Сан дараагийн алхмыг хийх юм байна гэж би ойлгосон. 2020 оны 4 дүгээр сарын 27-ны шөнө Монгол улсыг хариуцаж байгаа Аллан менежерээс ҮЗЗ-ийн даргад хандан албан ёсны мэдэгдэл ирүүлсэн. Энэ нь COVID-19-тэй тэмцэх хариу арга хэмжээний талаар ба Монгол улс үүнд 2 арга замаар оролцох боломжтой.

1. Хөтөлбөрүүдийн санхүүжилтээс гаргах: Глобаль сан улс орнуудад батлагдсан нийт санхүүжилтийн 5% тэнцэх санхүүжилтийг эмзэг бүлгийн хүн амыг хамгаалах, эмчилхэд зориулах боломжтой болгосон. Глобаль сан ашиглаагүй үлдсэн хөрөнгө, санхүүжилтийн хэмнэлт, зарим тохиолдолд үйл ажиллагааны санхүүжилтийг дахин хуваарилах боломжийг улс орнуудад олгож байгаа. Энэ процесс бол манай дээр явагдсан ба нийт 171,560 ам.доллар буюу нийт санхүүжилтийн 4,6%-тай тэнцэж байгаа үүнийг бол заавал хүсэлт бөглөж явуулах шаардлагагүй ҮЗЗ-ийн гишүүдийн саналыг авч батлуулах боломжтой.
2. C19RM буюу COVID-19 Response Mechanism гэсэн шинэ механизм нь 2020-2022 оны 3 жилийн санхүүжилтийн 10 хүртэлх хувийн санхүүжилтийн дэмжлэг авах боломжтой бөгөөд энэ механизм нь нийт 500 сая ам.долларын санхүүжилттэй ба Монгол улс 13 сая ам.долларын санхүүжилт авах эрх авсан. Үүнийг авахын тулд Funding Request Form гэсэн маягтыг бөглөж 2020 оны 5 сарын 31-ний өдрөөс өмнө илгээх ёстой.

Үүнээс гадна нэг асуудал гарсан, өчигдөр орой Алланаас Цогзолмаа зохицуулагч бид 2 луу имэйл ирсэн. Эрүүл Мэндийн Яамны сайд Глобаль Сангийн ханган нийлүүлдэг газар луу захиа явуулсан ба энэ нь COVID-19 оношлох 1500 ш тест оношлуур авахтай холбоотой, уг ажлыг гардаж хийсэн ЭМЯ-ний мэргэжилтэй удахгүй ирэхээр хэдэн төгрөгний үнэтэй, ямар оношлуурын талаар тодорхой мэдээлэл өгнө.

Өнөөдөр бидний шийдэх эхний асуудал нь 171,560 ам.долларын хэмнэлтийн санхүүжилтийн асуудлыг 20 гишүүн дэмжиж, 1 гишүүн татгалзсанаар байдлаар Глобаль Сан руу явуулаад үлдсэн нэг гишүүн өөрөө тайлбараа явуулах гэсэн асуудал байна. Хоёрдахь асуудал нь ЭМЯ-с явуулсан оношлуур авах хүсэлтийг хэрхэн яаж оруулж шийдэх асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Б. Мягмар: ХЗН зохицуулагч Цогзолмаа, Лхамсүрэн болон СОНА Багын ахлагч Мохан гуай нар оролцож байна. Оюундарийн танилцуулсан COVID-19 холбоотой асуулт байна уу?

П. Анузаяа: COVID-19-тэй холбоотой 2 механизмын 2 дахь дээр 10 хүртэлх хувь гэсэн байгаа юу эсвэл яг 10% гэсэн байгаа юу, захиан дээрээ юу гэсэн байгаа вэ?

Б. Оюундарь: 10 хүртэлх хувь гэсэн байгаа, үүнтэй холбоотой Алланаас би ахин тодруулахад дэлгэрэнгүй бодож явуулсан байсан. Нийтдээ 10% гэдэг нь 1,334,433 ам.доллар ба үүнээс 171,560 ам.доллараа хасаад нийт 1,162,873 ам.долларын санхүүжилт хүсэх боломжтой. Мөн 500 сая доллараас санхүүжилт хүсэх тохиолдолд тэргүүлэх 2 чиглэл байгаа ба 1 дэх нь 2020-2022 оны санжүүжилтийн 3,4%-тай тэнцэхүйц буюу батлагдах магадлал өндөртэй, 2 дахь буюу 3,4-6,4% хүртэлх нь бол амалж байгаа мөнгөн дүн биш бөгөөд бусад улс орнуудын хэрэгцээ шаардлагыг харгалзан олгоно.

Ц. Пүрэвжав: 500 сая ам.долларын санхүүжилтээ зөв тайлбарлахгүй бол Монгол улсад 500 сая ам.долларын санхүүжилт өгөх гэж байгаа юм шиг ойлгогдоод байна. Мөн 1 гишүүн татгалзсан байгаа гэсэн тэр гишүүн нь цаашаа тайлбараа өгч чадах уу?

Б. Оюундарь: Ерөнхийдөө тэр гишүүн нь яг шууд татгалзаагүй, горимын санал дэвшүүлсэн байгаа, энэ нь нүүр нүүрээ харж хуралдаж хурлын протоколд саналаа оруулмаар байна гэсэн хүсэлт тавьсан байгаа.

Б. Мягмар: Одоогын COVID-19-тэй нөхцөл байдалд аль болох цахим байдлаар, шуурхай асуудлыг шийдэх шаардлагатай байна. Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлөөс нэг дор 10-с дээш хүн цуглахгүй эсвэл 2, 2 метрийн зайтай суух эсвэл онлайнаар хуралд гэсэн чиглэл гаргасан байгаа. Өнөөдрийн хурлаар ҮЗЗ-ийн хурлыг хэрхэн хийх талаар шийдэе. Мөнхжаргал гишүүний гаргаж байгаа санал нь бол буруу зөрүү зүйл байхгүй зарчмын хувьд байх ёстой байдаг л санал. Жишээ нь: Манай МҮЭ-ийн 2 өдөр явагддаг хурал Zoom-р онлайн байдлаар хуралдахад 2 цаг л үргэлжилсэн. Энэ нь мөнгө болоод санхүү хэмнэсэн үр дүнтэй хурал болсон. ҮЗЗ-ийн хурлыг мөн Zoom-р хийгээд хурлын дарга болон зарим гишүүд нийлсэн 10 хүн байгаад бусад гишүүд нь гэр болон ажлаасаа хуралд оролцох боломжтой. Гэхдээ бас бүх гишүүд Zoom ашиглах боломжтой эсэхийг нь мэдэхгүй байна.

П. Анузаяа: ДЭМБ-ын Dr.Sergey дарга бол онлайнаар санал авахыг зарчмын хувьд дэмжиж байгаа, учир нь Монгол оронд төдийгүй дэлхийн даяар энэхүү цар тахалтай тэмцэж хариу арга хэмжээг яаралтай авч байгаа. Энэхүү хэмнэгдсэн 171,560 ам.доллар нь бусад 2 төсөлд болох ХДХВ/ Сүрьегийн төслүүдэд харшлахгүй хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байгаа учраас дэмжиж байна гэж саналаа хэлүүлсэн. Өнөөдрийн Гүйцэтгэх Хорооны хурлын хөтөлбөрийг Dr.Sergey даргад танилцуулахад дээрх саналыг хэлээрэй гэсэн байгаа. Цогзолмаа даргын өгсөн хэмнэгдсэн санхүүжилтийн дүнд үндэслэн ЭМЯ-аас өгсөн шаардлагатай байгаа хэрэгслийг авах нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаа ДЭМБ.

Б. Мягмар: Тэгвэл онлайн хурал хийхүү, яах вэ?

П. Анузаяа: Тэр тал дээр би санал хэлэх боломжгүй байна.

Н. Цогзолмаа: Zoom утсан дээр татаж аваад ашиглах боломжтой болсон байсан. Тэгэхээр компьютер ч заавал шаардлагагүй хангалттай дата байхад л хуралдах боломжтой болсон. Миний хувьд Zoom-р байна уу ямар нэг байдлаар хуралдаад ажлын явцыг цаг алдалгүй шийдээд явах л хэрэгтэй байна.

Б. Оюундарь: ҮЗЗ-ийн гишүүдээс санал авах явцад зарим гишүүдээс COVID-19-тэй холбоотой эмнэлэгийн ажилчдад эм, хамгаалах хэрэгсэл зэргийг авах саналыг хэлж байсан. Мөн Глобаль Сангийн үндсэн төсөл хөтөлбөр хэрэгжихэд саадгүй байх талаар нэг гишүүн санал хэлсэн байсан. Цогзолмаа эгчээс асуухад COVID-19 болоод салбар хүлээн авагч байгууллагуудын үйл ажиллагаа тасарсан эсвэл хүндрэл бэрхшээл тулгарсан асуудал гарсан уу?

Н. Цогзолмаа: Одоогоор бол COVID-19-тэй холбоотой сургалтууд хийгдэхгүй байна мөн цэр цуглуулах зэрэг ажлууд хөл хориотой холбоотой хийгдэхгүй байна. Уул нь 5 сар гэхэд хийгдэнэ гэж төлөвлөж байсан, одоо 6 сараас хийгдэнэ гэж найдаж байна. Зарим үйл ажиллагаа нь индикаторуудтай шууд холбоотой байдаг тул тэр үйл ажиллагаануудыг заавал хийх ёстой. Одоогийн байдлаар 30 сая төгрөг мөн ашиглагдаагүй байгаа ба энэ нь 10 жилийн сурагчдын

дунд хийгдэх сургалт 9 сарыг хүртэл хийгдэх боломжгүй болсон байгаатай холбоотойгоор аль болох боломжтой бүх санхүүжилтээ гаргаж өгч байгаа. 1 дүгээрт ханшийн зөрүүнээс үүссэн төсөв, 2 дугаарт 2018-2019 оны зарим үйл ажиллагааны хэмнэгдсэн төсвөөс бий болсон төсөв учир энэ нь Глобал Сангийн үйл ажиллагаанд харшлахгүй цаанаасаа хураагдаад авчихсан хөрөнгө байгаа ба үүнийг бид нар ийм зүйлд зарцуулах талаар танилцуулаад буцааж авах хүсэлтээ өгөх хэрэгтэй.

Ц. Пүрэвжав: Онлайнар хуралдах эсвэл биеэрээ цуглаж хуралдах ч бас хэцүү байх, тиймээс нөгөө гишүүнд эвтэйхэн ойлгуулаад эсвэл 20 гишүүн нь дэмжсэн 1 гишүүн нь түтгэлзсэн байдлаар цааш нь явуулсан дээр байх гэж бодож байна.

Б. Оюундарь: ЭМЯ-ны оношлуур авах хүсэлтийг хэмнэгдсэн 171,560 ам.долларын хүсэлтэйгээ цуг 2020 оны 5 сарын 31-ний өдрөөс өмнө явуулах юм чинь тэрнээс өмнө Zoom-р ч байна уу ямар нэг байдлаар хуралдаад түтгэлзсэн гишүүн нь хурлын протоколд хэлмээр байгаа санаагаа оруулаад онлайнар хурлаа хийгээд ажлаа явуулж байвал дээр юм уу? Ханшийн зөрүүнээс хэмнэгдсэн төсөв болох 171,560 ам.доллар болон 2020-2022 оны төсвөөс авах 10%-ийн санхүүжилтийн төсвөө хамт явуулах эсэхийг би ахин тодруулая. Эсвэл 171,560 ам.долларын хүсэлтээ түрүүлээд явуулж байж болох эсэхийг мөн асууя.

П. Анузаяа: Би 1 зүйл тодруулах гэсэн юм. 2020-2022 оны төсвийн 10%-ийн санхүүжилт нь зөвхөн COVID-19-тэй холбоотой зарцуулагдах юмуу эсвэл ХДХВ/Сүрьеэгийн төсөлтэй хамт явагдах юмуу?

Б. Оюундарь: Зөвхөн COVID-19-д зарцуулагдах юм байна лээ.

Б. Мягмар: Тэгэхээр 1 дүгээр асуудал дээр Глобал сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр COVID-19 цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний талаар танилцуулж, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцэн батлах гэсэн байна, үүнтэй холбоотой оруулж ирж байгаа санал чинь юу вэ? ХЗН-ээс оруулж ирж байгаа 31 сая төгрөгөө нэмээд бүх ҮЗЗ-ийн гишүүдийнхээ саналыг тусгаад батлах гэдгийг албажуулах юмуу, яг ямар саналтай байна вэ?

Б. Оюундарь: ЭМЯ бол 171,560 ам.долларын санал дээрээ байгаа, тэхээр 171,560 ам.доллараа түрүүлээд явуулах боломжтой бол дэмжсэн 20 гишүүнийхээ имэйлийг бусад холбогдох бичиг баримтуудтайгаа Глобал Сан руу явуулж байхуу эсвэл дараагийн хүсэлтэйгаа хамт явуулах уу гэж бодож байна.

Б. Мягмар: Үндсэн хүлээн авагчаас ирсэн дахин төлөвлөлттэй холбоотой санал ирээд багагүй хугацаа өнгөрсөн тиймээс бид нар аль болох цаг хугацаа алдахгүй байх үүднээс эхний ажлаа дараагийн асуудалтай нийлүүлж удаахгүйгээр яаралтай илгээмээр байна. Үүнтэй холбоотой Мохан гуайгаас зөвлөмж авдаг юмуу.

Индермохан: Одоо хэрэгжиж байгаа төслүүдийн ханшийн зөрүүнээс үүссэн 171,560 ам.доллараа 2020-2022 оны 10%-ийн санхүүжилтийн 1,334,433 ам.долларын дүнгээсээ хасаад тэгээд ойролцоогоор 1,162,873 ам.доллараа одоо байгаа болон ирэх 3 жилийн хүрээнд бүрэн байдлаар батлах ёстой зарчмын дагуу. 171,560 ам.доллар нь нийт санхүүжилтийн нэг хэсэг нь бөгөөд Алланаас санхүүжилтийн хүсэлтээ 2 хэсэгт хуваан явуулж болох эсэхийг асуух хэрэгтэй. Миний бодол бол Санхүүжилтийн хүсэлтээ нийлүүлээд 1 хүсэлт илгээх нь дээр гэж бодож байна.

Б. Оюундарь: Өчигдөр би Алланаас тодруулсан, 171,560 ам.доллар дээр Санхүүжилтийн хүсэлтийн форм бөглөх шаардлагагүй. Харин 2020-2022 оны санхүүжилтээс мөнгө хүсч байгаа бол Санхүүжилтийн хүсэлтийн форм бөглөх шаардлагатай. Тэгэхээр салангид явуулж болох юм шиг санагдаж байна. Гэхдээ Алланаас ахин тодруулж асууя.

Б. Мягмар: ҮЗЗ-ийн даргын хувьд нийт 21 гишүүн 21-лээ санал нэгтгэйгээр зөвшөөрсөн байдлаар өргөн баримаар байна. Оюундарь, Цогзолмаа дарга, ЭМЯ-ний дахин төлөвлөлтийг боловсруулсан мэргэжилтэн нар Мөнхжаргал гишүүний санал, хүсэлт болоод санхүүжилтын талаар сайн тайлбарлаж ойлгуулаад дэмжсэн имэйл аваад нэг ч гэсэн ажлаа явуулах хэрэгтэй байна. Дараагийн 84 дэх удаагийн хурал дээрээ шинэ дарга томилох болон бусад хэлэлцэх шаардлагатай асуудлаа оруулаад 2020 оны 5 сарын 31-ний өдрөөс өмнө товлол дээр байх гэж бодож байна. Гишүүдээс дэмжиж байна гэсэн имэйл ирсэн байсан үүнийг батлах хэрэгтэй байгаа тиймээс гишүүд рүү Гүйцэтгэх хорооны хурал хуралдсан тухай мэдэгдээд ахин батлаж байна гэсэн имэйл авах хэрэгтэй үүн дээр нэмээд Цогзолмаа даргаас сүүлд ирсэн зүйлийг нэмээд ахин бүх гишүүд рүү имэйл явуулж батлуулах хэрэгтэй.

Н. Цогзолмаа: Сүүлд нэмэгдсэн санхүүжилт нь тусдаа асуудал учраас тусад нь баталсан дээр байх.

Б. Оюундарь, Ц. Пүрэвжав: Гишүүдээс ирүүлсэн дэмжиж байна гэсэн имэйл нь баталсан гэсэн утгатай байгаа.

Б. Мягмар: Тэгвэл заавал баталж байна гэсэн имэйл ахин авах шаардлагагүй юм байна. Одоо тэгвэл Мөнхжаргал гишүүнтэй уулзаж ойлгуулаад болж өгвөл дэмжиж буй имэйлийг нь аваад болохгүй бол түтгэлзсэнээр нь цааш нь явуулая. Бүгдээрээ 1-р асуудал дээрээ санал хураагаад батлая (Гүйцэтгэх хорооны гишүүд батлав). За одоо 2-р асуудал руугаа ороё.

Б. Оюундарь: 2-р асуудал руу орхоос өмнө ЭМЯ-ны мэргэжилтэн А. Баярзаяа COVID-19 лабораторийн шинжилгээг Xpert® Xpress SARS-CoV-2 оношлуураар хийх хэрэгцээний тухай танилцуулахаар ирсэн байна.

А. Баярзаяа: (COVID-19 лабораторийн шинжилгээг Xpert® Xpress SARS-CoV-2 оношлуураар хийх хэрэгцээний тухай танилцуулга хийв) Нэг оношлуурын үнэ ойролцоогоор 20 ам.доллар бөгөөд Хилийн боомтын ойрын цэг сум, аймгуудад нийт 13,094 ширхэг оношлуур авах шаардлагатай байгаа ба энэ нь нийтдээ ойролцоогоор 261,880 ам.доллар болж байна.

Ц. Пүрэвжав: Хэрвээ GeneExpert төхөөрөмжийг нь авах бол энэ нь нөгөө 171,560 ам.доллартаа багтах юмуу, хаанаас мөнгө нь гарах билээ?

Б. Оюундарь: COVID-19 холбоотой шинэ механизм байгуулдсан гэж байсан, тийшээгээ хүсэлтээ өгөөд тэндээс санхүүжилт авах боломжтой. Ингэхийн тулд ҮЗЗ-өөс зөвшөөрөл авч хийгдэнэ.

Н. Цогзолмаа: Бид нарт 2018, 2019 оны гүйцэтгэлээс 350,000 ам.доллар хэмнэгдсэн байгаа. Үүнээс энэ GeneExpert төхөөрөмжийг авсан зүйтэй юм боловуу гэж харж байна, Глобаль Сан руу хүсэлт бичиж батлуулах процесс нь өөрөө удах учир.

Ж.Лхамсүрэн: Глобаль сангийн дэмжлэгтэй төслүүдийн 2018, 2019 оны үйл ажиллагааны гүйцэтгэлээс 350,000 ам.доллар хэмнэгдсэн байгаа ба хэрвээ энэ мөнгийг дахин төлөвлөлт хийж зарцуулахгүй бол хураагдах эрсдэлтэй байгаа. Энэхүү хэмнэлт нь юунаас

үүссэн бэ гэхээр нэгж үнийн зөрүү болон ачилт тээврийн зардалаас үүссэн. Энэхүү хэмнэгдсэн төсвийг юунд зарцуулж болох талаар салбар нэгж байгууллагуудтайгаа ярилцаад 3 зүйлд зарцуулаа гэсэн шийдэлд хүрсэн.

1. 2020 онд Сүрьеэгийн нэмэлт санхүүжилтээр 12 ширхэг GeneExpert-ийн аппарат авч байгаа, энэ нь 2018-2020 оны төсөвт анх тусгагдаагүй байсан тиймээс үүн дээр нэмж 1 жилийн хэрэглээний 126,467 оношлуурыг худалдан авах шаардлагатай болж байна. Үүнд барааны болон тээврийн хөлсөнд 151,760 ам.доллар зарцуулах тооцоо гарсан. Энэ нь 4 модультай 12 аппаратанд өдөрт нэг удаа шинжилгээ хийх, 22 ажлын өдрөөр 12 сар хэрэглэнэ гэж тооцсон.

2. Сүрьеэгийн эмч мэргэжилтнүүдийг халдвараас хамгаалах зорилгоор амны хаалтны тооцоог гаргахдаа 1 хүн 1 амны хаалтыг 72 цаг зүүнэ гэж тооцоолж төлөвлөсөн. 2019 онд Мэргэжлийн Хяналтаас Сүрьеэгийн нэгжүүдэд хяналт шалгалт хийхдээ 1 амны хаалтыг 1 удаа хэрэглэх зөвлөмж өгсөн учир амны хаалтны хэрэгцээ дутагдалтай болсон. Уг хэмнэгдсэн мөнгөөр 840 эмч мэргэжилтнүүдийн хэрэгцээнд шаардлагатай байгаа 104,687 ширхэг амны хаалтыг 82,660 ам.доллараар худалдан авах шаардлагатай байна.

3. ХЗН-ийн хэрэгцээнд одоо ашиглагдаж байгаа 2 машин нь 2008 болон 2010 онд худалдан авсан. Үндсэн хөрөнгийн элэгдлийн журмаар 6 жилийн дотор өртгөө нөхнө гэж тооцоолж актлах эрх үүсдэг. Төслийн машинуудын хувьд 2 нугалсан хэрэглээтэй байна. Одоогийн байдлаар 210,000-250,000 км туулсан хэрэглээтэй байна, бид ажилчдынхаа аюулгүй байдлыг бодсон ч тэр 2 машиныг акталж шинэ машин авах шаардлагатай байна. Тиймээс 1 машиныг 50,000 ам.доллар, 2 машин нь нийтдээ 100,000 ам.долларын худалдан авалтанд зарцуулна гэж тооцсон.

Энэ талаар Алланд хэлж энэ нь материаллаг уу материаллаг бус уу гэж тодруулахад материаллаг бус гэсэн төрөлдөө орно гэсэн тул ҮЗЗ-өөр батлуулчих юм бол Глобал Сан руу явуулах боломжтой байгаа.

Б. Мягмар: Шинээр авах машин нь ямар маркын машин байх вэ?

Ж.Лхамсүрэн: Механик араатай суудлын машин буюу Toyota Landcruiser болон Prado маркын машин байгаа. Глобал Сангийн www.warmbo.org вэбсайтаас харахад үнэ нь ойролцоогоор ийм байсан.

Н. Цогзолмаа: Энэ санхүүжилтийг авахын тулд Монголд ямар нэгэн процесс явагдахгүй шууд тэр захиалгын системээр нь дамжуулан зөвхөн авах боломжтой юм байна лээ.

П. Анузаяа: Материаллаг бус зардал нь нийт хэдэн хувийг эзлэж байгаа бол?

Ж.Лхамсүрэн: Нийт интервэнцийн 30%-ийг эзлэж байгаа. Нийт 9 интервэнц байгаа ба интервэнц болгон нь өөр өөр хувьтай байгаа.

Ж. Одгарьд: 350,000 ам.долларын ахиад өөр хэмнэлт байгаа гэж байсан, энэ нь юунаас хэмнэгдсэн хөрөнгө байгаа вэ?

Ж.Лхамсүрэн: Бидэнд ахиад 350,000 ам.долларын хэмнэлт байгаа, энэ нь 2020 онд нэмэлт 1,5 сая ам.долларын санхүүжилт баталсанаас гарсан хэмнэлт байгаа. Энэ нь 350,000 ам.долларыг 2-р эгнээний эмийн худалдан авалтанд гэж тооцоолж байсан ба

бид одоо байгаа эмийн нөөцөө тооцоолж үзээд 2-р эгнээний эмийн худалдан авалт хийх шаардлагагүй гэсэн тооцоолол гарч хэмнэгдсэн хөрөнгө байгаа. Иймээс бид ахин хэмнэгдсэн 350,000 ам.долларыг юунд зарцуулах талаар ахин тооцоолол хийж ҮЗЗ-өөр батлуулна.

Ж. Одгарьд: Хэрвээ эмийн нөөц дуусч, хүрэхгүй бол яах вэ?

Ж.Лхамсүрэн: 2020 болон 2021 гээд жил бүр эмний мөнгө төсөвлөгдсөн байдаг тэрнээс гадна ЭМЯ-наас мөн 20-30%-ийг нь хангадаг болсон.

П. Анузаяа: Эмний нөөц илүү гарсан гэж байна. Энэ нь өвчлөл буурсантай холбоотой байна уу, юунаас шалтгаалж байна вэ?

Ж.Лхамсүрэн: Энэ нь 2 шалтгаантай байгаа.

1. Өвчлөл буурсан. Жишээ нь: 2019 онд 318 хүнийг эмчилгээнд хамруулна гэж байсан бол гүйцэтгэл нь 100 хүнээр дутуу явж байна. Үүнтэй холбоотой 100 хүний эм нь хэмнэгдээд яваад байгаа учраас нөөц ихэссэн байгаа.

2. Өвчний эрт илрүүлэлттэй холбоотой. Өвчний илрүүлэлт багассан мөн зарим өвчтөн нь нас барсан эсвэл эмчилгээ хийлгэхээс татгалзсан зэргээс шалтгаалж байна. Мөн бид богино хугацааны эмчилгээний горим буюу 9 сарын эмчилгээний горимд шилжсэнтэй холбоотой эмийн зарцуулалт багассан. Хуучин бол 24 сарын эмчилгээ хийгддэг байсан.

Б. Мягмар: 1,5 сая ам.долларын нэмэлт санхүүжилтийн хүсэлт өгөхдөө тооцоолол муу хийгдсэн юмуу, саяхан уул нь энэ хүсэлтийг өгсөн биз дээ?

Ж.Лхамсүрэн: Тийн, тэр бол 2019 оны сүүлээр хийгдсэн. Гэхдээ тэр үед Сүрьеэгийн тандалтын судалгаа хийхэд тийм байх магадлалтай гэж Глобаль Сан руу явуулахад тэндээс жилийн дараа гэхэд та нарын тооцоолсоноос их байх магадлалтай гээд өндөрөөр баталсан.

Б. Мягмар: За ойлголоо. Одоо асуултаа таслаад санал хураая. Бид энд бол батлахгүй. Ерөнхийдөө хэмнэгдээд үлдсэн хөрөнгийг Монгол орондоо шингээх хэрэгтэй гэж би хувьдаа үзэж байна. Тиймээс дараагийн ҮЗЗ-ийн хурлаас өмнө үндсэн хүлээн авагч болох ЭМЯ-аас ийм юм авах хүсэлтээ албан ёсоор ирүүлэх нь зүйтэй байх. Ингээд ҮЗЗ-ийн 84 дэх удаагийн хуралд саяны 350,000 ам.долларын асуудал болон дахин хэмнэгдсэн 350,000 ам.долларын асуудлаа амжвал цуг оруулж ирвэл зүйтэй байх.

Н. Цогзолмаа: Энэ 350,000 ам.долларыг одоо энэ хурал дээр танилцуулж байгаа гэж ойлгож байгаа, тиймээс 171,560 ам.доллартайгаа цуг явуулах хүсэлтэй байна. Харин дараагийн хурал дээр үлдсэн 350,000 ам.долларыг оруулж ирье гэж бодож байна.

Б. Мягмар: 350,000 ам.долларыг ҮЗЗ-ийн гишүүдэд танилцуулагдаагүй учир болохгүй. Тийм учраас 84 дэх удаагийн хурлаар оруулна, оруулахдаа хоёр 350,000 ам.доллараа ойлгомжтой салгаад зэрэг оруулах хэрэгтэй. Харин 171,560 ам.долларын асуудал нь ҮЗЗ-ийн гишүүдэд танилцуулагдаад батлагдсан.

Н. Цогзолмаа: Нэмэлт санхүүжилт авахын тулд Санхүүжилтийн Хүсэлтийн Форм бөглөх шаардлагатай тэр нь маш нарийн тооцоолол, зайлшгүй шаардлагатай гэсэн шалтгаанаа мөн сайн гаргасан байх хэрэгтэй, хэрвээ сайн хийгдээгүй бол батлагдахгүй байх магадлалтай. Харин 350,000 ам.долларын нэгэнт хэмнэгдсэн төсөв байгаагаар зарцуулах хүсэлт өгвөл илүү хурдан батлагдах юм аа. Бид нарын энэ яриад байгаа 350,000, 350,000 ам.доллар нь энэ ондоо ашиглахгүй бол он гарлаа бол шууд хүчингүй болох юм.

Ж.Лхамсүрэн: Бидний бас яараад байгаа шалтгаан нь захиалгаа өнөөдөр өглөө гэхэд тээвэрлэлт нь доод тал нь 2 сарын хугацаа шаардагдана, хэрвээ энэ ондоо багтахгүй бол ирэх жилийн төсвөөс хасагдах учраас яараад байгаа юм л даа.

Б. Мягмар: Тэгэхээр дараагийн хурал дээр энэ асуудалуудаа албан болгоод үндсэн хүлээн авагч болох ЭМЯ-ны сайдын гарын үсэгтэй албан бичиг болгон оруулж ирэх шаардлагатай. Тэр хурлыг Zoom юм уу өөр байдлаар зохион байгуулан шуурхай шийдэх болно. 3-р хэлэлцэх асуудлыг дараагийн хурал руу шилжүүлэх үү, Оюундарь аа. Хүмүүс бас яараад байх шиг байна.

Н. Цогзолмаа: Надад нэг хэлэх санал байна. Тогтвортой байдлын зөвлөлд гадаадаас зөвлөх авах болоод тэр хүн нь 4 сард ирэх байсан боловч COVID-19 холбоотой 5 сарыг дуустал ирэх боломжгүй болсон. Тиймээс онлайнаар зөвлөгөө өгөөд явж байгаа, гэтэл энэ талаар Энхзаяа дарга мэдээгүй надад мэдэгдэлгүйгээр ийт үйл ажиллагаа зохион байгууллаа гэж уурласан. Уул нь энэ талаар бүх гишүүдэд мэйлээр мэдэгдээд явсан гэж ойлгож байгаа.

Б. Оюундарь: Өнгөрсөн 2020 оны 3 сарын 5-нд болсон Гүйцэтгэх хорооны хурлаар Энхзаяа дарга байсан, тэр хурлын үеэр танилцуулаад яригдсан.

Б. Мягмар: Сүүлийн асуудлаа ярилцаж шийдэе. ҮЗЗ-ийн 84 дэх удаагийн хурлын тов, хөтөлбөрийг тогтоё. ХЗН-ээс ирүүлсэн хоёр 350,000 ам.долларын асуудал, шинэ дарга сонгох зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэж шийдэе. Миний хувьд хорио цээрийн байдал дуусах хүртэл түр байж байгаад хийсэн ажлаа тайлагнаад дараагийн даргатаа ажлаа нэр төртэй хүлээлгэн өгье гэж бодсон юм. Гэтэл зарим нэг гишүүн нь яаралтай солих хүсэлтэй байгаа бол би цаашид байгаад байх шаардлагагүй гэж бодож байна. Тиймээс Гүйцэтгэх Хорооны гишүүд ярилцаад дараагийн даргаа олоод 84 дэх удаагийн хурлын хэлэлцэх асуудалд оруулвал яасан юм бэ. Хяналтын хорооны дарга нь энэ асуудлыг удаа дараа хөндөж байгаа, ер нь бол энэ удаагийн төсөл өргөн барьтал түр ажиллахыг хүссэн учраас би түр ажиллаж байгаа юм.

84 дэх удаагийн хурлын хэлэлцэх асуудлууд:

1. Зохион байгуулалтын асуудал

А. ҮЗЗ-ийн даргыг сонгох

Б. Хяналтын хорооны гишүүн сонгох

2. ХЗН-ээс ирүүлсэн хоёр 350,000 ам.долларын асуудал

Б. Оюундарь: 84 дэх удаагийн хурлыг 5 сарын 2 дахь 7 хоногт зохион байгуулвал ямар вэ?

Б. Мягмар: 5 сарын 3 дахь 7 хоног буюу 5 сарын 20 хавьцаа гэж товлоё. За ингээд хурлаа өндөрлөе.

ГҮЙЦЭТГЭХ ХОРООНЫ ШИЙДВЭР:

Хөтөлбөр 1. Глобаль сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр COVID-19 цартахалатай тэмцэх хариу арга хэмжээний талаар танилцуулж, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцэн батлах

Б. Мягмар: Хоёр 350,000 ам.долларын хэмнэгдсэн санхүүжилт нь ҮЗЗ-ийн гишүүдэд танилцуулагдаагүй учир болохгүй. Тийм учраас 84 дэх удаагийн хурлаар оруулна, оруулахдаа хоёр 350,000 ам.доллараа ойлгомжтой салгаад зэрэг оруулах хэрэгтэй. Харин 171,560 ам.долларын асуудал нь ҮЗЗ-ийн гишүүдэд танилцуулагдаад нийт 21 гишүүнээс 20 гишүүн нь дэмжиж баталсан.

Хөтөлбөр 2. Глобаль сангийн дэмжлэгтэй төслүүдийн үйл ажиллагааны хэмнэгдсэн санхүүжилтийг дахин хуваарилах тухай

Б.Оюундарь: 2019 оны 11 сарын 14-ний өдөр Эрүүл мэндийн сайдын А511 тоот шилжилт болон тогтвортой байдлын төлөвлөгөө боловсруулах удирдах зөвлөл байгуулах тухай тушаал батлагдсан. 11 сарын 22-ны өдөр ажлын хэсэг анхны хуралаа хийгээд дотоодын 5 зөвлөх сонгон шалгаруулахаар шийдвэрлэсэн байгаа. Шилжилтийн үед тогтвортой байдлыг хадгалах үүднээс Глобаль сангаас Монгол улсад олон улсын зөвлөх ажиллуулах боломжтой гэсэн байгаа. Иймд ҮЗЗ-ийн зүгээс 12 сарын сүүлээр олон улсын зөвлөх шалгаруулж авах зар байрлуулаад 1 сарын эхээр ажлын байрны шалгаруулалт явуулах болно.

Хөтөлбөр 3. Шилжилт болон тогтвортой байдлын төлөвлөгөө боловсруулах ажлын үйл явцын талаар танилцуулах

Б. Мягмар: Тэгэхээр дараагийн хурал дээр энэ асуудалуудаа албан болгоод үндсэн хүлээн авагч болох ЭМЯ-ны сайдын гарын үсэгтэй албан бичиг болгон оруулж ирэх шаардлагатай. Тэр хурлыг Zoom юм уу өөр байдлаар зохион байгуулан шуурхай шийдэх болно. 3-р хэлэлцэх асуудлыг дараагийн хурал руу шилжүүлэх үү, Оюундарь аа. Хүмүүс бас яараад байх шиг байна.

Н. Цогзолмаа: Надад нэг хэлэх санал байна. Тогтвортой байдлын зөвлөлд гадаадаас зөвлөх авах болоод тэр хүн нь 4 сард ирэх байсан боловч COVID-19 холбоотой 5 сарыг дуустал ирэх боломжгүй болсон. Тиймээс онлайнаар зөвлөгөө өгөөд явж байгаа, гэтэл энэ талаар Энхзаяа дарга мэдээгүй надад мэдэгдэлгүйгээр ийт үйл ажиллагаа зохион байгуулаа гэж уурласан. Уул нь энэ талаар бүх гишүүдэд мэйлээр мэдэгдээд явсан гэж ойлгож байгаа.

Б. Оюундарь: Өнгөрсөн 2020 оны 3 сарын 5-нд болсон Гүйцэтгэх хорооны хурлаар Энхзаяа дарга байсан, тэр хурлын үеэр танилцуулаад яригдсан.

Хөтөлбөр 4. ҮЗЗ-ийн 84 дэх удаагийн хурлын тов, хөтөлбөрийг батлах

Б. Мягмар: 84 дэх удаагийн ҮЗЗ-ийн хурлын хэлэлцэх асуудлууд:

1. Зохион байгуулалтын асуудал

А. ҮЗЗ-ийн даргыг сонгох

Б. Хяналтын хорооны гишүүн сонгох

2. ХЗН-ээс ирүүлсэн хоёр 350,000 ам.долларын асуудал

Б. Мягмар: 84 дэх удаагийн ҮЗЗ-ийн хурлыг 5 сарын 3 дахь 7 хоног буюу 5 сарын 20 хавьцаа гэж товлоё.

Хурал 14:00 цагт өндөрлөв.

Хянасан:.....Б.Мягмар, ҮЗЗ-ийн дарга

Боловсруулсан:.....Т.Батчимэг, ҮЗЗ-ийн Ажлын албаны
туслах ажилтан